



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022. 02. 29 № 07/845
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН
НЭГДСЭН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ М.БАТБААТАР
ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

ОХУ-ын Техникийн зохицуулалт, хэмжил зүйн Холбооны агентлагийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн “Цементийг гэрчилгээжүүлэх, тохирлын үнэлгээ хийх дүрэм”-д өөрчлөлт оруулж, ОХУ-д импортолж буй цементийн багц бүрт хил дээр шалгалт хийх заалт”-ыг цуцалж, цемент импортлох процедурыг хялбарчлах шийдвэр гаргасан байна.

“Росстандарт”-ын зүгээс Евразийн эдийн засгийн холбооны гишүүн бус орнуудаас импортолж буй цементийн багц бүрийг хил дээр 28 хоногийн туршид хянаж шалгадаг байсан бөгөөд энэ шалгалтыг цуцласнаар импортын цементийн бичиг баримтыг бүрдүүлэх хугацаа 28 хоногоор багасч, энэхүү арга хэмжээ нь цементийн дотоодын хэрэгцээг хангах, барилгын материалын үнийн өсөлтийг бууруулахад эерэгээр нөлөөлнө гэж үзэж байгаагаа ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны дэд сайд Виктор Евтухов мэдэгдсэн байна.

Иймд дээрх мэдээлэл, шийдвэрийг Монгол Улсын цемент үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлж, өөрийн бүтээгдэхүүнээ ОХУ-ын зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: 3 хуудастай

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Н.АНХБАЯР

116220812